



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ  
АХУЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ДАРХАН СУМ

2017 ОН

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО**

Хүнс, хөдөө аж ахуй салбарын 2017 оны тэргүүлэх зорилтуудын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагааны зорилт, хүрэх түвшинг гүйцэтгэлээр нь харьцуулан тогтоох, тэдгээрийн хоорондын алдаа, зөрүүг илрүүлэн дүн шинжилгээ хийж шалтгааныг тодруулан дүгнэлт зөвлөмж, гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

**ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ**

Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагааны тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Хүнс, Хөдөө Аж Ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2017 оны А/159 тоот тушаал, хавсралтад дурдсан аргалчлалыг удирдлага болгов.

Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Сайдаас Аймгийн засаг дарга, ХХААГ-ын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт, Аймгийн Засаг даргаас ХХААГ-ын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт, Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт, Аймгийн нийгэм эдийн засгийн зорилтын биелэлт, Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын биелэлтийн үнэлгээг газрын хяналт шинжилгээ-үнэлгээний багийн гишүүдээр хэлэлцэж, хэлтсүүдийн жилийн эцсийн мэдээ болон холбогдох албан тушаалтнуудтай уулзаж тодруулах замаар цуглуулсан мэдээ, мэдээлэлтэй харьцуулан үнэлгээг хийв.

**ГУРАВ. ҮНЭЛГЭЭ**

**3.1. БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ**

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ**

Дархан-Уул аймгийн Засаг даргын 2016- 2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, өтөлбөрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөнд 5 салбарын 40 зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхээс тухай жилд хэрэгжүүлэх арга хэмжээний шалгуур үзүүлэлтээр 85,9 хувийн гүйцэтгэлтэй байна. Орхон Хонгор, Дархан суманд “АТАР-60” төслийг хэрэгжүүлэх, сумдад мал эмнэлгийн үйлчилгээний цэгийг шинээр байгуулах, үхэр, бог малыг ээмэгжүүлэх ажлыг үргэлжлүүлэх, “Орхон кластер” төслийг боловсруулж батлуулан, хэрэгжилтийг хангуулах ажлын биелэлт хангалтгүй эрчимжүүлэх шаардлагатай. / Хөтөлбөрийн хэрэгжилтийг Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 396 тоот албан бичгийн хавсралтаар аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлсэн./

д/д	Биелэлт	Бүгд	Үйлдвэржүүлэлтийн чиглэлээр	Хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр	Газар тариалангийн чиглэлээр	Мал аж ахуйн чиглэлээр	Мал эмнэлгийн чиглэлээр
1	Хяналтанд авсан нийт шийдвэрийн тоо	40	9	7	9	10	5
2	Үүнээс	“бүрэн хэрэгжсэн” - 100.0%	26	8	4	5	3
3		“хэрэгжих шатанд”-70.0%	10	1	2	3	1
4		“хэрэгжилт хангалтгүй”- 40.0%	4		1	1	1
5		“хэрэгжээгүй”-0%					
6		“хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”					
7		<b>Хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ, хувь</b>	<b>85,9</b>	<b>96,6</b>	<b>82,8</b>	<b>83,3</b>	<b>85,0</b>

## ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨЛЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГААС БАТАЛСАН ДЭД ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ

Аймгийн Засаг дарга хяналтанд авч, хэрэгжүүлэхийг үүрэг болгосон “Ногоон хувьсгал-III” дэд хөтөлбөрийг батлах тухай, , “Дархан-Үр” дэд хөтөлбөрийг батлах тухай, “Туслах аж ахуйн хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөр батлах тухай, “Бордоо төслийг дэмжих тухай” аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн тогтоолын 4 заалтыг хяналтад аван хэрэгжилтийг хангуулан ажилласнаар холбогдох хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгээр 2017 оны жилийн эцсийн байдлаар 100,0 хувийн хэрэгжилттэй 5,00 онооны үнэлгээтэй байна.

/Дэлгэрэнгүй тайланг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 396 тоот албан бичгийн хавсралтаар аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлсэн./

### АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХЭЭР ДЭВШҮҮЛСЭН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Төлөвлөгөөгөөр нийт 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 100-н хувийн биелэлттэй 4 заалт байна.

/Дэлгэрэнгүй тайланг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 396 тоот албан бичгийн хавсралтаар аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлсэн./

### 3.2. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

#### БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, аймгийн Засаг дарга нартай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг 7 үндсэн чиглэлээр 96 арга хэмжээг төлөвлөн ажилласан. Төлөвлөгөөт арга хэмжээний биелэлт 90.3 хувьтай.

Тухайн жилийн цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан үр тариа, малын тэжээл, хадлан бэлтгэлийн чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлт нь өнгөрсөн оны мөн үеийнхээс буудай 6.7 мянган тонноор, хүнсний ногоо 3.1 мянган тонноор, тосны ургамал 799.6 тонноор буурсан, аймаг, сумын нөөцөд бэлтгэх хадлан тэжээлийн нөөцлөлт 65,2 хувьтай байна.

Мал хамгаалах сангаас авсан зээлийн эргэн төлөлт 25.8 хувьтай, Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас авсан зээлийн эргэн төлөлт 16.5 хувьтай байна. /Төлөвлөгөөний биелэлтийг хавсаргав./

Төлөвлөгөөний биелэлтийг салбараар авч үзвэл:

№	Салбарын нэр	Арга хэмжээний тоо	Биелэлтийн хувь
1	Дотоод үйл ажиллагаа	18	98.0
2	Мал аж ахуйн чиглэлээр	13	88.4
3	Мал эмнэлгийн чиглэлээр	24	93.0
4	Газар тариалангийн чиглэлээр	12	85.0
5	Хөнгөн, жижиг, дунд үйлдвэр, ахуйн үйлчилгээний чиглэлээр	13	97.0
6	Хүнсний чиглэлээр	13	100.0
7	Хоршоо, ХАА-н биржийн чиглэлээр	3	70
<b>Дундаж үзүүлэлт</b>			<b>90.3</b>

### ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДААС ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Үр дүнгийн гэрээнд 63 арга хэмжээг хэрэгжүүлэхээс бүрэн хэрэгжсэн 54, хэрэгжих шатандаа 6, хэрэгжилт хангалтгүй 2, хэрэгжилтийг тооцох боломжгүй, хугацаа болоогүй 1 арга хэмжээ байна. Малчид, хоршоод хамгийн бага зардлаар түүхий эдээ зах зээлийн үнээр борлуулах боломжийг хангаж, ХАА-н үйлдвэрлэл эрхлэгч хоршоодыг биржийн арилжаанд оруулах талаар Хөдөө аж ахуйн биржтэй хамтран ажиллах, Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх төслийг Орхон суманд хамтран хэрэгжүүлэх гэсэн 2 арга хэмжээ нь хэрэгжилт хангалтгүй гэж үнэлэгдсэн бөгөөд энэ нь санхүүжилт нь шийдэгдээгүй, төсөл хэрэгжих хугацааг буруу тооцсонтой холбоотой байна. /Гэрээний биелэлтийг тооцож хүргүүлсэн./

д/д	Биелэлт	Бүгд	Нэг.Бодлого төлөвлөлт чиглэлээр	Хоёр.Мал аж ахуйн салбарын чиглэлээр	Гурав. Мал эмнэлгийн чиглэлээр	Дөрөв.Газар тариалангийн салбарын чиглэлээр	Тав.Хөнгөн үйлдвэрийн салбарын чиглэлээр	.Зургаа.Хүнсний үйлдвэрийн салбарын чиглэлээр	Долоо.Жижиг, дунд үйлдвэр, хоршооны салбарын чиглэлээр	
1	Хяналтанд авсан нийт шийдвэрийн тоо	63	13	13	4	11	7	10	5	
2	Үүнээс	“бүрэн хэрэгжсэн” - 100.0%	54	9	11	4	9	6	10	5
3		“хэрэгжих шатанд”- 70.0%	6	2	2		1	1	-	-
4		“хэрэгжилт хангалтгүй”-40.0%	2	1	-		1	-	-	-
5		“хэрэгжээгүй”-0%		-	-			-	-	-
6		“хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”	1	1	-		-	-	-	-
7		Хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ, хувь	93.65%	90,00%	95,38%	100,0 %	91.81%	95.71%	100.0%	100.0%

### АЙМГИЙН ХХААГ-ААС СУМДЫН МАЛ ЭМНЭЛЭГ, ҮРЖЛИЙН ТАСАГТАЙ БАЙГУУЛСАН ТУХАЙН ЖИЛИЙН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.3.–ын а, б, 36.1.1, Монгол Улсын малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах хуулийн 4.5, 5.1, 5.3, 6.1, 6.3, 6.4, 11.1, Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 15, 16, 17, 18, 19, Тариалангийн тухай хуулийн 20.2.6., 23.1., 26.10., 27 дугаар зүйл, Газрын тухай хуулийн 54.2., 54.4., Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 17.1.1. заалтууд, Монгол мал, Үйлдвэржилт 21:100 үндэсний хөтөлбөр, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, Дархан Уул аймгийн “Хөдөө аж ахуйн салбарыг 2021 он хүртэл хөгжүүлэх нэгдсэн бодлого” /2009-2021/, Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн үйлдвэрийн Сайдын 2017 оны А/159 тоот тушаал болон бусад холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төрийн албаны үйл ажиллагааг шуурхай, оновчтой зохион байгуулахад төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, нэгдсэн удирдлагаар хангах зорилгоор ХХААГазар нь сумдын Засаг дарга, МЭҮТ тасагтай 2017 онд хамтран ажиллах гэрээг байгуулан гэрээний хавсралтаар 24 зорилт 29-30 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг баталж, жилийн эцэст дүгнэн ажиллалаа.

Үнэлгээгээр Дархан сум 80.6, Хонгор сум 91.7, Орхон сум 80.0, Шарын гол сум 81.2хувьтай үнэлэгдэж дунджаар 83,4 хувьтай байна.

Тасагт ажиллаж байгаа мэргэжилтний мэргэжил, ажлын туршлага, ачаалал зэргээс шалтгаалан тайлагналт хангалтгүй, гэрээний биелэлтийг нэгтгэн дүгнэхэд хүндрэлтэй, цаашид ХХААГ-аас мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, ажлын үр

дүнг үнэлэх үнэлгээ, гэрээний хавсралтаар хүлээлгэх үүргийг тодорхой хэмжигдэхүйц болгох, газар дээр нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх шаардлагатай.

Д/д	Сумын нэр	Арга хэмжээний тоо	100-аас дээш хувийар биелсэн, үр дүнгтэй	Үүний дотор			Үнэлгээ	
				Тодорхой үр дүнд хүрсэн -70%	Эрчимжүүлэх шаардлагатай- 40%	Үр дүнгүй		
1.	Дархан	Хөнгөн,ЖДҮ, ахуйн үйлчилгээ хоршоо, ХААБ-ийн чиглэлээр	6	3	1	2	-	75.0
2.		Хүнсний үйлдвэрийн чиглэлээр	7	4	2	1	-	82.9
3.		Газар тариалан	7	5	1	1	-	87.1
4.		Мал аж ахуй	8	3	4	1	-	77.5
5.	Орхон	Хөнгөн,ЖДҮ, ахуйн үйлчилгээ хоршоо, ХААБ-ийн чиглэлээр	5	3		2	-	76.0
6.		Хүнсний үйлдвэрийн чиглэлээр	6	3	3		-	85.0
7.		Газар тариалан	8	5		3	-	77.5
8.		Мал аж ахуй	13	9		4	-	81.5
9.	Шарын гол	Хөнгөн,ЖДҮ, ахуйн үйлчилгээ хоршоо, ХААБ-ийн чиглэлээр	6	3		3	-	70.0
10.		Хүнсний үйлдвэрийн чиглэлээр	6	4	1	1	-	85.0
11.		Газар тариалан	6	4		2	-	80.0
12.		Мал аж ахуй	12	8	4		-	90.0
13.	Хонгор	Хөнгөн,ЖДҮ, ахуйн үйлчилгээ хоршоо, ХААБ-ийн чиглэлээр	6	4	1	1	-	85.0
14.		Хүнсний үйлдвэрийн чиглэлээр	7	4	3		-	87.1
15.		Газар тариалан	6	5	1		-	95.0
16.		Мал аж ахуй	11	11			-	100.0
17.	<b>Ерөнхий дундаж үнэлгээ</b>							<b>83,4</b>

## ГҮЙЦЭТГЭЛ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны 1360-12 тоот зөвлөмж, ХХААХҮЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас болон ХХААГ-ын ХШҮ-ний багаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж,

зөвлөмжийн биелэлтийг заалт тус бүрээр тооцож гаргахад 97.0 хувийн биелэлттэй байна./Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлтийг шинэчлэн гаргаж хавсаргав./

### **3.3. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ**

#### **БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ**

ЗГ-ын 2017 оны 89 дүгээр тогтоолын дагуу байгууллагын ил тод байдлын үнэлгээний биелэлтийг дүгнэж үзэхэд үйл ажиллагааны ил тод байдлын үзүүлэлт 94,2 хувьтай, хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлт 90,0 хувьтай, дундаж үзүүлэлт 92,1 хувьтай, үнэлэх боломжгүй 2 зорилт байна.

Үнэлэх боломжгүй 2 зорилт нь

“8.Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;”

-Тус газар нь ямар нэг тусгай зөвшөөрөл олгодоггүй болно.

7.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;

- Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж буй чиг үүрэг байхгүй болно.

Цахим хуудасны мэдээллийг шалгуур үзүүлэлтийн дагуу шинэчлэх, нэмэлт мэдээллүүд оруулах шаардлага байна гэж үзлээ.

/Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг хавсаргав/

#### **ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ**

Дархан-Уул аймаг дахь Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгтэй байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу Монгол Улсын Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан асуудлаар салбар чиглэл бүрээр асуулга бэлтгэн хүргүүлж, Дархан, Хонгор, Орхон, Шарын гол сумын мал аж ахуй, газар тариалан эрхэлдэг, хамаарал бүхий 500 гаруй иргэдийг хамруулан үнэлгээг хийлгэхэд Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2017 оны үйл ажиллагаанд нийт оролцогсдын 46,1 хувь нь хангалттай, 34,6 хувь нь дунд зэрэг гэсэн үнэлгээг өгсөн байх ба хэрэглэгчийн үнэлгээний түвшин өмнөх оныхоос ахисан, 82,5 хувийн үзүүлэлттэй байна.

### **3.4. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ**

#### **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны А-159 тоот тушаалын гуравдугаар хавсралт, аргачлалын 13- 19 дүгээр хүснэгтээр үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг гаргахад бүрэлдэхүүн хэсгийн дундаж үнэлгээ 97,4 хувьтай байна.

Хүнсний салбарт 5 чиглэл, 33 үзүүлэлтээр гаргасан үзүүлэлтээс үзэхэд шинэчилсэн аргачлалаар зарим үзүүлэлтийн суурь түвшинг тодорхойлох, мэдээлэл цуглуулах боломжгүй байна. Үр дүнгийн үзүүлэлтийн ерөнхий дүн 97.0 хувьтай байна.

Мал эмнэлгийн салбар 7 чиглэл, 26 үзүүлэлтээр үнэлэх хүснэгтийн дагуу хяналт шинжилгээ хийхэд 100 хувийн биелэлттэй байна. 2017 онд аймгийн хэмжээнд тус салбарт багагүй хөрөнгө оруулалт хийгдсэн, халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр анхаарч ажилласан нь зохих үр дүнд хүрсэн байна.

Мал аж ахуйн салбар 9 чиглэл, 29 үзүүлэлтээр үнэлэх хүснэгтийн дагуу хяналт шинжилгээ хийхэд 97.7 хувьтай дүгнэгдсэн. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо сумын түвшинд 86.0 хувьтай, аймгийн түвшинд 91,0 хувьтай, тэмээ, адууны тоо буурсан дүнтэй байна.

Газар тариалангийн салбар 21 чиглэл, 54 үзүүлэлтээр үнэлэх хүснэгтийн дагуу хяналт шинжилгээ хийхэд цаг уурын нөхцөл байдалтай холбоотойгоор газар тариалангийн суурь үзүүлэлтүүд болон нэгж талбайгаас авах ургацын хэмжээ буурсан, харин усалгаатай газар тариалангийн талбайн хэмжээ зорилтот төвшинд хүрсэн байна. Ерөнхий үнэлгээ 88.1 хувьтай байна. Тухайн жилийн зорилтот төвшинг тогтооход байгаль, цаг агаарын нөхцөл, бусад үзүүлэлтийг харгалзан үзэх шаардлагатай.

Хөнгөн үйлдвэрийн салбар 5 чиглэл, 23 үзүүлэлтээр 99,0 хувийн жижиг, дунд үйлдвэрийн салбар 4 чиглэл, 16 үзүүлэлтээр 100 хувийн, хоршооны салбар 4 чиглэл, 16 үзүүлэлтээр 100 хувийн үнэлгээтэй гарсан бөгөөд дээрх салбар нь бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөөр тус газарт шилжиж ирсэн, суурь үзүүлэлтийг тооцох боломжгүй байна.

## **ДӨРӨВ. ДҮГНЭЛТ**

Дархан-Уул аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2017 оны үйл ажиллагаа, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Аймаг нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ, Засгийн газрын гишүүн аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт, Байгууллагын ил тод байдлын үнэлгээ тайлангуудын биелэлтэд хяналт-шижилгээ, үнэлгээ хийхэд ерөнхий дундаж нь **92.2** хувьтайгаар дүгнэгдэв.

Мал хамгаалах сан, Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас олгосон зээлийн мэдээллийг тухай бүрт нь ирүүлж, хяналт тавьж ажиллах, орон нутгийн оролцоог дээшлүүлэх, төсөв хөрөнгө нь шийдэгдээгүйгээс хийгдээгүй ажлыг үнэлэхэд ажлын идэвх оролцоо, зохион байгуулсан ажлын үр дүнг харгалзан үзэх шаардлагатай.

## **ТАВ. ЗӨВЛӨМЖ**

Мал хамгаалах сан, Тариалан эрхлэлтийг дэмжих санд үүссэн өр, авлагыг барагдуулах талаар сангуудтай хамтарч ажиллах төлөвлөгөө болосвруулж хэрэгжүүлэх.

Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, хэрэглэгчдэд чиглэсэн мэдээлэл түгээх үйл ажиллагааг түлхүү хэрэгжүүлэх.

Сумдын мал эмнэлэг, үржлийн тасагтай байгуулах гэрээ, гэрээний хавсралтад өөрчлөлт оруулах, тасгийн дүрэм, үйл ажиллагааны хүрээний асуудлуудыг тусгах.



Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг тодорхой тусгаж өгөх, тавигдах шаардлагыг бүрэн хангасан байх.

ТАНИЛЦСАН:

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ  
АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА

О.ЧИМЭДЦЭРЭН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХҮНИЙ НӨӨЦ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТ, СУРГАЛТ, ТАЙЛАН МЭДЭЭ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.НЯМДОРЖ

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН  
(2017 оны үйл ажиллагааны үр дүн)

Баримт бичиг	Үзүүлэлт	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, хувь
1	2	3
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	Аймаг , нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	<b>85.9</b>
	Үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн Засаг дарга, ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт	<b>100.0</b>
	Аймаг нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	<b>100.0</b>
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	Төсвийн Ерөнхийлөн захирагчаас ХХААГ-ын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт	<b>93.6</b>
	Байгууллагын тухай жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт	<b>90.3</b>
	Аймгийн ХХААГ-аас сумдын Мал эмнэлэг, үржлийн тасагтай байгуулсан тухайн жилийн хамтран ажиллах гэрээний биелэлт	<b>83.4</b>
	Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт	<b>97.0</b>
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ	<b>92.1</b>
	Хэрэглэгчийн үнэлгээ	<b>82.5</b>
Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	Хүнсний салбар	97.0
	Мал эмнэлгийн салбар	100
	Мал аж ахуйн салбар	97.7
	Газар тариалангийн салбар	88.1
	Хөнгөн үйлдвэрийн салбар	99
	Хоршооны салбар	100
	Жижиг, дунд үйлдвэрийн салбар	100
Үр дагаврын үнэлгээний дундаж		<b>97,4</b>
<b>Ерөнхий үнэлгээ:</b>		<b>92,2</b>